




ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2020 ОНЫ УЛСЫН ЭЭЛЖИТ ТООЛЛОГЫН **ӨВӨРХАНГАЙ** **АЙМГИЙН** НЭГДСЭН ДҮН

/ Хураангуй /



ӨВӨРХАНГАЙ 2020 ОН

ᠬᠤᠨ ᠠᠮ, ᠣᠷᠤᠨ ᠰᠤᠭᠤᠨ ᠲᠤᠯᠯᠣᠭ᠎ᠠ
ᠨᠡᠭᠳᠦᠰᠡᠨ ᠳᠤᠨ
ᠶ᠋ᠢᠬᠤᠷᠠᠭᠤᠢ

АГУУЛГА

1. ХҮН АМ	3
2. ХҮН АМЫН ҮНДЭС, УГСАА	6
3. ШАШИН.....	7
4. ХҮН АМЫН СУУРЬШИЛ	8
5. ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН.....	9
6. БОЛОВСРОЛ, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ	10
7. ӨРХ, ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ.....	10
8. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ	12
9. ИНТЕРНЭТ, ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ.....	13
10. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ.....	14
11. ГАДААДАД ОРШИН СУУГАА ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭД.....	16
12. СУУЦНЫ НӨХЦӨЛ.....	17

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

ХҮСНЭГТ 1. ХҮН АМЫН ТОО ХҮЙСИЙН ХАРЬЦАА 2020 ОН	4
ХҮСНЭГТ 2. ХҮН АМЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, ХҮЙСИЙН ХАРЬЦАА, 2010, 2020 ОН	4
ХҮСНЭГТ 3. ХОТ, ХӨДӨӨГИЙН ХҮН АМЫН ТОО, ХҮЙСЭЭР, ХҮЙСИЙН ХАРЬЦАА, 2010, 2020 ОН	6
ХҮСНЭГТ 4. ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХАРЬЯАТ ИРГЭДИЙН ТОО, ҮНДЭС, УГСАА, ХУВИАР, 2010, 2020 ОН	6
ХҮСНЭГТ 5. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ШАШИНТАНГУУД, ТООГООР	7
ХҮСНЭГТ 6. ХҮН АМЫН ТОО, НУТАГ ДЭВСГЭР, НЯГТШИЛ ТОО, ХУВИАР 2020 ОН	8
ХҮСНЭГТ 7. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ТОО, ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ, ХУВИАР, 2000, 2010, 2020 ОН	11
ХҮСНЭГТ 8. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРӨЛ, 2010, 2020 ОН	17
ХҮСНЭГТ 9. ГЭР, БАЙШИН, ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРӨЛ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2019, 2020 ОН	18


ЗУРГИЙН ЖАГСААЛТ

ЗУРАГ 1. ХҮН АМЫН ТОО, ТООЛЛОГО ЯВАГДСАН ОНУУДААР	3
ЗУРАГ 2. ХҮН АМЫН ТОО	3
ЗУРАГ 3. ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2010, 2020 ОН	5
ЗУРАГ 4. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ШАШИН ШҮТЛЭГТЭЙ ХҮН АМ, ШАШНЫ ТӨРӨЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН	7
ЗУРАГ 5. ХҮН АМЫН СУУРЬШИЛ, СУМДААР 2020 ОН	9
ЗУРАГ 6. ШИЛЖИГЧДИЙН ТОО, ХУГАЦАА, НУТАГ ДЭВСГЭРЭЭР, 2020 ОН	10
ЗУРАГ 7. АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН БАЙДАЛ	10
ЗУРАГ 8. ӨРХИЙН ТОО, ӨРХИЙН ХЭЛБЭРЭЭР, 2020 ОН	11
ЗУРАГ 9. АНХНЫ ГЭРЛЭЛТИЙН ДУНДАЖ НАС	11
ЗУРАГ 10. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, ХЭЛБЭРЭЭР, 2010, 2020 ОН	12
ЗУРАГ 11. ҮЙЛДЛИЙН ЧАДВАР, ХҮЙСЭЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН	13
ЗУРАГ 12. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВРАГА, ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ, 2020 ОН	14
ЗУРАГ 13. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХИЙН ТАЛААРХ БҮДҮҮВЧ, 2020 ОН	15
ЗУРАГ 14. ХҮН АМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХ, ХУВИАР, 2020 ОН	15
ЗУРАГ 15. ГАДААДАД ОРШИН СУУГАА ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХҮН АМЫН ТОО, УЛСААР	16
ЗУРАГ 16. ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭД, ЯВСАН ЗОРИЛГО, ХУВИАР, 2020 ОН ...	17
ЗУРАГ 17. ӨРХИЙН СУУЦНЫ ТӨРӨЛ, 2020 ОН	18
ЗУРАГ 18. ХҮН АМЬДРАН СУУХ ЗОРИУЛАЛТТАЙ НИЙТ СУУЦ БОЛОН ХҮН БАЙНГА АМЬДАРДАГ СУУЦНЫ ТОО, ТӨРЛӨӨР, 2020 ОН	19

1. ХҮН АМ


Өвөрхангай аймгийн хүн амын тоо 2020 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн байдлаар 116 732, өрхийн тоо 33 062, болсныг тоолж гаргалаа. Аймгийн хүн амаас гадаадад 6 ба түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа Монгол улсын харъяат иргэд 1 013 байна. Мөн тус аймгийн нутаг дэвсгэрт 6 ба түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа гадаадын харъяат 18 иргэн байна.

ЗУРАГ 1. ХҮН АМЫН ТОО, ТООЛЛОГО ЯВАГДСАН ОНУУДААР



Хүн амын тоо 2010-2020 оны хооронд жилд дунджаар 1.7 хувиар өссөн байна. Жилийн дундаж өсөлт өмнөх тооллогоос нэмэгдсэн нь хүн амын цэвэр өсөлт сүүлийн арван жилд их байсантай холбоотой юм.

ЗУРАГ 2. ХҮН АМЫН ТОО



Аймгийн хүн амын 49.8 хувь нь эрэгтэйчүүд, 50.2 хувь нь эмэгтэйчүүд байна. 2020 оны тооллогоор суурин хүн амын тоо 115 719 болж 2010-2020 оны хооронд 9 жилийн хугацаанд Өвөрхангай аймгийн нутаг дэвсгэр дэх хүн ам 15.2 мянган хүнээр өссөн байна. 2020 оны тооллого хүртэл Өвөрхангай аймгийн хүн ам тасралтгүй өсч байна.

ХҮСНЭГТ 1. ХҮН АМЫН ТОО ХҮЙСИЙН ХАРЬЦАА 2020 ОН

Тооллого явагдсан он	Хүн амын тоо (мян.хүн)			Хүйсийн харьцаа
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	
1956	49.9	24.1	25.8	93.4
1963	56.2	27.8	28.4	97.9
1969	66.8	33.5	33.3	100.6
1979	82.4	41.4	41.0	101.0
1989	96.5	48.6	47.9	101.5
2000	111.4	55.6	55.8	99.6
2010	101.3	50.9	50.4	101.0
2020	115.7	57.5	58.1	99.0

Хүн амын хүйсийн харьцаа (100 эмэгтэйд ногдох эрэгтэй) 2010 онд 101.0 байсан бол 2020 оны тооллогоор 99.0 болж 1.9 пунктээр буурчээ.

ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ

Өвөрхангай аймгийн хүн ам нь насны бүтцийн хувьд ерөнхийдөө залуу хэвээр байгаа ба 0-14 насны хүүхэд 31.3 хувь, 15-64 насны хүн ам 64.2 хувь, 65, түүнээс дээш насны хүн ам 4.5 хувь эзэлж байна.

Хүйсийн харьцаа өмнөх тооллогын үетэй харьцуулахад 99.0 болж 1.9 пунктээр буурчээ. Мөн хүйсийн харьцаа нь 35 ба түүнээс дээш насны бүлэгт буурч байгаа нь эрэгтэйчүүдийн дунд нас баралт харьцангуй илүү байдагтай холбоотой.

ХҮСНЭГТ 2. ХҮН АМЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, ХҮЙСИЙН ХАРЬЦАА, 2010, 2020 ОН

Насны бүлэг	2010		2020		Хүйсийн харьцаа*	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	2010	2020
БҮГД	50 333	50 111	57 599	58 138	100.4	99.0
0-4	5 892	5 590	6 812	6 462	105.4	105.4
5-9	4 776	4 636	6 306	6 171	103.0	102.1
10-14	5 691	5 415	5 389	5 037	105.1	106.9
15-19	4 796	4 327	4 698	4 522	110.8	103.8
20-24	4 417	4 038	5 156	4 703	109.4	109.6
25-29	4 364	4 308	4 638	4 328	101.3	107.1
30-34	4 133	4 141	4 565	4 459	99.8	102.3
35-39	3 887	3 980	4 100	4 031	97.7	101.7
40-44	3 427	3 585	3 844	3 935	95.6	97.6
45-49	2 888	2 938	3 469	3 644	98.3	95.1
50-54	1 955	2 233	2 808	3 189	87.6	88.0
55-59	1 290	1 404	2 310	2 650	91.9	87.1
60-64	875	1 023	1 401	1 837	85.5	76.2
65-69	755	889	863	1 177	84.9	73.3
70+	1 187	1 604	1 240	1 993	74.0	62.2


Тайлбар: *100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо

Хүн амыг насны бүтцийн хувьд таллан хувааж байгаа голч нас 26 болсон нь хүн амын тэн хагас нь 26-аас доош, үлдсэн 50 хувь нь түүнээс дээш насныхан байна.

Энэ нь 2010 оны тооллогын дүнгээс 1 насаар хойшилсон байна. Нийт хүн амын 0.9 хувь нь буюу 1 013 хүн гадаадад 6, түүнээс дээш сарын хугацаагаар гадаадад оршин сууж байна. Хөдөлмөрийн насны 100 хүнд ноогдох тэжээлгэгч хүн амын тоо 55.8 байна. Хүн ам зүйн ачаалал 2020 онд 2010 оноос 1.1 пунктээр буурчээ.

Хүйсийн харьцаа насны бүлэг ахих тутам буурч байгаа нь эрэгтэйчүүдийн нас баралт эмэгтэйчүүдийнхээс харьцангуй илүү байдагтай холбоотой бөгөөд үүнийг ахимаг насны бүлэгт, жишээлбэл, 65, түүнээс дээш насанд хүйсийн харьцаа 73, 62 болж огцом буурч байгаагаас харж болно. Насны бүлэг дэх хүйсийн харьцаа нь төрөх үеийн хүйсийн харьцаа, нас баралтаас гадна хүйсийн ялгаатай шилжих хөдөлгөөнөөс шалтгаалдаг. Нас, хүйсийн бүтцийг харуулах өөр нэг гол үзүүлэлт бол хүн амын нас, хүйсийн суварга билээ.

ЗУРАГ 3. ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2010, 2020 ОН



Аймгийн төв болон хөдөөд хүйсийн харьцаа ялгаатай байна. Хөдөөгийн хүн амын хүйсийн харьцаа аймгийн дунджаас өндөр байгаа нь хөдөөнөөс төврүү гол төлөв эмэгтэйчүүд илүү шилжин ирж байгааг харуулж байна.

ХҮСНЭГТ 3. АЙМГИЙН ТӨВ, ХӨДӨӨГИЙН ХҮН АМЫН ТОО, ХҮЙСЭЭР, ХҮЙСИЙН ХАРЬЦАА, 2010, 2020 ОН

Аймгийн төв, Хөдөө	2010				2020			
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа
БҮГД	100 444	50 333	50 111	100.4	115 737	57 599	58 138	99.1
Аймгийн төв	38 027	18 559	19 468	95.3	32 891	15 723	17 168	91.6
Хөдөө	62 417	31 774	30 643	103.7	82 846	41 876	40 970	102.2

2. ХҮН АМЫН ҮНДЭС, УГСАА

Хүн ам, орон сууцны 2020 оны улсын тооллогоор Монгол Улсын харьяат иргэдийн үндэс угсааны талаарх мэдээллийг цуглуулахдаа өмнөх тооллогоос дэлгэрэнгүй бүлгээр авсан. Өмнөх тооллогод үндэс угсааг 29 бүлэг байсныг 31 болгож өргөжүүлсэн.

ХҮСНЭГТ 4. ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХАРЬЯАТ ИРГЭДИЙН ТОО, ҮНДЭС, УГСАА, ХУВИАР, 2010, 2020 ОН


Үндэс угсаа	2010		2020	
	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь
МОНГОЛ УЛСЫН ХАРЬЯАТ- БҮГД	100 422	100.0	115 719	100.0
Халх	100 207	99.80	115 268	99.6
Казах	13	0.01	45	0.04
Дөрвөд	13	0.01	88	0.08
Буриад	14	0.01	35	0.03
Баяд	19	0.02	44	0.04
Дарьганга	4	0.00	18	0.01
Урианхай	1	0.00	21	0.02
Захчин	20	0.02	38	0.03
Дархад	3	0.00	14	0.01
Торгууд	7	0.01	23	0.02
Өөлд	34	0.03	68	0.06
Хотон	9	0.01	13	0.01
Мянгад	22	0.02	14	0.01
Барга	16	0.02	2	0.00
Үзэмчин	7	0.01	3	0.00
Хотгойд	2	0.00	10	0.01
Сартуул	21	0.02	5	0.00
Түмэд	1	0.00	1	0.00
Бусад гадаад(Монгол харьяат)	-	0.00	8	0.01
Гадаадын харьяат	-	0.00	18	0.01
Харьяалалгүй	-	0.00	0	0.00

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор Өвөрхангай аймгийн харьяат суурин хүн амын 99.6 хувийг Халхууд эзэлж, өмнөх тооллогоос 0.2 пунктээр буурсан байна. Дөрвөдүүд нийт хүн амд эзлэх хувийн жин 0.08 хувь байгаа нь Халхуудын дараа орж байна. Харин Сартуул, Мянгад, Барга, Үзэмчин угсаатнууд 2010 оноос буурсан байна.

3. ШАШИН

Аливаа шашныг шүтэх, эс шүтэх нь тухайн хүний итгэл үнэмшлийн хэрэг байна. Арван тав, түүнээс дээш насны хүн амын 89.6 хувь нь шашин шүтдэг, 10.4 хувь нь шашин шүтдэггүй гэж тоологдлоо. Шашин шүтлэгтэй хүмүүсийн 99.1 хувь нь буддын шашинтан байна.

ЗУРАГ 4. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ШАШИН ШҮТЛЭГТЭЙ ХҮН АМ, ШАШНЫ ТӨРӨЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН



ХҮСНЭГТ 5. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ШАШИНТАНГУУД, ТООГООР

ШАШНЫ ТӨРӨЛ	2010			2020		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Шүтдэггүй	13.8	16.1	11.6	10.4	11.5	9.3
Шүтдэг	86.2	83.9	88.4	89.6	88.5	90.7
Будда	85.2	83.1	87.3	88.8	87.7	89.9
Бөө	0.5	0.4	0.5	0.4	0.4	0.3
Христ	0.4	0.3	0.5	0.4	0.3	0.4
Бусад	0.1	0.1	0.1	0.0	0.1	0.1

4. ХҮН АМЫН СУУРЬШИЛ

Сумдуудын нутаг дэвсгэрийн хэмжээ харилцан адилгүйн зэрэгцээ хангай, тал хээр, говийн бүс хосолсон газар зүйн янз бүрийн бүст оршдог, байгалийн баялаг нутаг дэвсгэрт жигд бус тархсан, уур амьсгал газар зүйн бүсүүдэд ялгаатай, эрс тэс байдаг зэргээс хамааран сумдуудын хүн амын суурьшил, нягтрал, хөгжлийн түвшин өөр өөр байгаа нь зүй ёсны асуудал билээ.

ХҮСНЭГТ 6. ХҮН АМЫН ТОО, НУТАГ ДЭВСГЭР, НЯГТШИЛ ТОО, ХУВИАР 2020 ОН


СУМ	Хүн амын тоо	Нутаг дэвсгэр км.кв	Хүн амын нягтшил
БҮГД	115 737	62 895	1.8
Баян-Өндөр	3 651	3 248	1.1
Бүрд	2 898	2 581	1.1
Бат-Өлзий	7 585	2 428	3.1
Баруунбаян-Улаан	2 786	3 941	0.7
Баянго	3 830	3 543	1.1
Гучин-Ус	2 194	4 753	0.5
Есөнзүйл	2 908	2 211	1.3
Өлзийт	2 393	1 797	1.3
Зүүнбаян-Улаан	3 847	2 701	1.4
Богд	5 692	10 155	0.6
Нарийнтээл	3 571	2 702	1.3
Сант	3 570	2 564	1.4
Тарагт	3 145	3 192	1.0
Төгрөг	2 714	5 467	0.5
Уянга	9 520	3 139	3.0
Хайрхандулаан	3 479	4 138	0.8
Хужирт	6 773	1 718	3.9
Хархорин	12 290	2 241	5.5
Арвайхээр	32 891	376	87.5

Аймгийн нэг квадрат километр нутаг дэвсгэрт 2010 онд 1.6 хүн ногдож байсан бол 2020 онд 0.2 пунктээр өсч 1.8 хүн ногдож байна.

Улс төр, соёл, түүх, засаг захиргаа, цаг агаар, газар зүй зэрэг олон хүчин зүйлс хүн амын суурьшил, нягтралд нөлөөлдөг. Аймгийн хүн амын нягтралд хамгийн ихээр нөлөөлсөн хүчин зүйлсийн нэгд шилжих хөдөлгөөн орж байна.

Аймгийн хүн амын 28.4 хувь нь аймгийн төвд, 34.6 хувь нь Хангайн бүсэд, 22.1 хувь нь Хээрийн бүсэд, 14.9 хувь нь Говийн бүсэд амьдарч байна. Аймгийн суурин хүн амыг бүлэглэвэл 3000 хүртэл хүн амтай 6 сум, 3001-5000 хүртэл хүн амтай 7 сум, 5001-8000 хүртэл хүн амтай 3 сум, 8001-15000 хүртэл хүн амтай 2 сум, 15001 дээш хүн амтай 1 сум байна. Хамгийн их хүн амтай нь Арвайхээр сум 32 891, хамгийн бага хүн амтай нь Гучин-Ус сум 2 194 байна.


ЗУРАГ 5. ХҮН АМЫН СУУРЬШИЛ, СУМДААР 2020 ОН



5. ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

Төрснөөс хойших аймаг, нийслэл хоорондын шилжих хөдөлгөөнд оролцогч нийт суурин хүн амын 4.2 хувийг эзэлж байна.

ЗУРАГ 6. ШИЛЖИГЧДИЙН ТОО, ХУГАЦАА, НУТАГ ДЭВСГЭРЭЭР, 2020 ОН



6. БОЛОВСРОЛ, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ

Арав, түүнээс дээш насны хүн амын 94.4 хувь нь ямар нэгэн боловсролын түвшин эзэмшсэн байна. Харин 15, түүнээс дээш насны хүн амын 97.5 хувь нь бичиг үсэг тайлагдсан байна.

Боловсролын түвшин өмнө жилүүдээс харьцангуй өссөн ба бичиг үсэг мэддэггүй хүн амын түвшин буурчээ. Арав ба түүнээс дээш насны хүн амын дунд бичиг үсэг мэддэггүй хүн амын эзлэх хувь багассан байна. Харин дийлэнх нь буюу 27.2 хувь нь суурь боловсролтой байна.

ЗУРАГ 7. АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН БАЙДАЛ



* Нийт 10 ба түүнээс дээш насны хүн амын тоонд Монгол Улсад удаан хугацаагаар амьдарч байгаа гадаад улсын иргэдийг хамруулаагүй болно.

Дээд боловсролтой хүн амын түвшин 2010 онд 7.7 байсан бол 2020 онд 14.5 болж 6.8 пунктээр өссөн үзүүлэлттэй байна. Өвөрхангай аймгийн суурин хүн амд 10, түүнээс дээш насны боловсролгүй хүн амын эзлэх хувь 5.6 болж 2010 оноос 2.3 дахин буурсан эерэг үзүүлэлттэй байна.

7. ӨРХ, ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор өрхийн тоо 33 062 болж 2010 оноос 5 011 өрхөөр буюу 17.9 хувиар өссөн байна.

Аймгийн хэмжээнд 33.1 мянган өрх тоологдсоноос 65.5 хувь нь ам бүлээрээ байгаа өрх, 17.4 хувь нь нийлмэл ам бүлтэй, 16.9 хувь нь ганц бие, 0.2 хувь нь холимог ам бүлтэй өрх байна.

ЗУРАГ 8. ӨРХИЙН ТОО, ӨРХИЙН ХЭЛБЭРЭЭР, 2020 ОН



Нийт өрхийн дотор ам бүлээрээ буюу нөхөр, эхнэр, хүүхдийнхээ хамт амьдарч байгаа өрх дийлэнх хувийг эзэлж байна. Хэдийгээр хот /аймгийн төв/-ын өрх 13.0 хувиар буурсан ч хөдөөгийн өрх 36.6 хувиар нэмэгдсэн нь өрхийн тоо ийнхүү өсөхөд нөлөөлсөн байна.

ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ

Өвөрхангай аймгийн 15, түүнээс дээш насны хүн амд огт гэр бүл болоогүй хүмүүсийн эзлэх хувь 2010 онд 28.4 хувь байсан бол 2020 онд 34.2 хувь болж 5.8 пунктээр өссөн байна.

ХҮСНЭГТ 7. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ТОО, ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ, ХУВИАР, 2000, 2010, 2020 ОН


	2010		2020	
	мян. хүн	Дүнд эзлэх хувь	мян. хүн	Дүнд эзлэх хувь
БҮГД	68 444	100.0	79 544	100.0
Огт гэр бүл болоогүй	19 468	28.4	27 203	34.2
Гэр бүлтэй ¹	43 046	62.9	46 161	58.0
Цуцалсан ²	1 347	2.0	1 330	1.7
Бэлэвсэн	4 583	6.7	4 850	6.1

Тайлбар: ¹ батлуулаагүй гэр бүлтэй хүмүүсийг оруулсан.

² тусгаарласан хүмүүсийг оруулсан.

Дээрх хүснэгтээс харахад сүүлийн 10 жилд огт гэр бүл болоогүй хүн амын тоо өсч, харин тусгаарласан, цуцалсан хүн амын тоо ялимгүй буурчээ. Аймгийн 15, түүнээс дээш насны хүн амын дунд гэр бүлээ цуцалсан хүний эзлэх хувь 2010 оныхоос 0.3 пунктээр, бэлэвсэн хүний эзлэх хувь 0.6 пунктээр тус тус буурчээ.

ЗУРАГ 9. АНХНЫ ГЭРЛЭЛТИЙН ДУНДАЖ НАС




Анхны гэрлэлтийн дундаж нас 27.7 болсон бөгөөд 2010 онтой харьцуулахад гурван насаар хойшилсон байна. Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн анхны гэрлэлтийн насны ялгаа ойролцоогоор 3-4 насны зөрүүтэй байна.

8. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ

Өвөрхангай аймгийн хэмжээнд нийт 3 972 хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгаа нь нийт суурин хүн амын 3.4 хувийг эзэлж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 2 185 буюу 55.0 хувь нь эрэгтэй, 1 787 буюу 45.0 хувь нь эмэгтэйчүүд байна.

Төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй иргэд өмнөх тооллогоос 199 буюу 11.3 хувиар өссөн нь сүүлийн 10 жилд агаарын бохирдол болон бусад хүчин зүйлийн нөлөөгөөр эхээс төрөхдөө л хөгжлийн бэрхшээлтэй байна гэсэн үг юм.

ЗУРАГ 10. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, ХЭЛБЭРЭЭР, 2010, 2020 ОН



Харин олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өмнөх тооллогоос 831 буюу 41.2 хувиар буурсан байна.

Хөгжлийн бэрхшээлийг хэлбэрээр нь авч үзвэл хөдөлгөөний бэрхшээл 2010 оны тооллогоос 33.6 хувь, харааны бэрхшээл 22.4 хувь, сонсголын бэрхшээл 38.1 хувь, ярианы бэрхшээл 49.8 хувь, сэтгэцийн бэрхшээл 4.8 хувиар тус тус буурсан байна.

Нийт бэрхшээлийн дийлэнх буюу 29.9 хувийг бусад (Хавсарсан болон бусад хөгжлийн бэрхшээлийг энд оруулав), 3.9 хувийг ярианы бэрхшээл эзэлж байгаа бөгөөд хамгийн бага хувийг эзэлж байна.

ҮЙЛДЛИЙН ЧАДВАР

Насны бүлгээр авч үзэхэд 35-39 насны үйлдлийн чадварын хүндрэлтэй хүмүүсийн хамгийн их хүндрэл нь сонсголын, өөрийгөө арчлах байгаа бол 50, түүнээс дээш насныхны хувьд алхах хүндрэл их байгаа нь нас ахих тусам дээрх хүндрэлүүд зонхилж байгааг харж болохоор байна.


ЗУРАГ 11. ҮЙЛДЛИЙН ЧАДВАР, ХҮЙСЭЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН



9. ИНТЕРНЭТ, ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ

Хүн ам, орон сууцны 2020 оны улсын тооллогоор Өвөрхангай аймгийн 6, түүнээс дээш насны суурин хүн амын 84.0 хувь гар утас хэрэглэж байна. Тэдний 47.2 хувь нь эрэгтэй, 52.8 хувь нь эмэгтэйчүүд байна. 15-59 насны хүн амын 95.2 хувь нь гар утас хэрэглэж байгаагаас 15-39 насныхан хамгийн их хэрэглэгчид байна.

ЗУРАГ 12. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВРАГА, ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ, 2020 ОН



Дэлхий нийтээр даяаршиж интернэтийн хэрэглээ маш хурдан өссөөр байгаа ба Монгол Улсад ч бас 3G болон 4G сүлжээ орж ирсэнээр гар утас болон байнга интернэт хэрэглэгчдийн тоо ихэссэн байна.

Тооллогын дүнгээр 6, түүнээс дээш насны суурин хүн амын 45.8 хувь интернэт хэрэглэж байна. Интернэт хэрэглэгчдийн 45.0 хувь нь эрэгтэйчүүд бол эмэгтэйчүүд 10.0 пунктээр их байна.


10. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ

Хөдөлмөрийн насны буюу 15, түүнээс дээш насны нийт хүн амын 64.5 хувь нь ажиллах хүчинд багтаж байгаа нь 2010 оноос 2.4 пунктээр өссөн бол ажиллах хүчнээс гадуурх хүн ам 2.4 пунктээр буурчээ. Ерөнхийд нь үзвэл ажиллах хүчний оролцооны түвшин өмнөх тооллогоос өссөн, ялангуяа хөдөлмөрийн насны хүн амд эмэгтэйчүүдийн ажиллах хүчний эзлэх хувь 29.0 хувь болж өмнөх тооллогын үеийнхээс 5.8 хувиар өссөн байна.

ЗУРАГ 13. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХИЙН ТАЛААРХ БҮДҮҮВЧ, 2020 ОН



ЗУРАГ 14. ХҮН АМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХ, ХУВИАР, 2020 ОН



Арван тав ба түүнээс дээш насны нийт хүн амын 62.5 хувь нь ажил эрхэлж байгаа бөгөөд нийт ажиллах хүчний 75.2 хувь нь хөдөөд байгаа нь аймгийн эдийн засгийн голлох салбар нь мал аж ахуй үйлдвэрлэлтэй холбоотой юм. Ялангуяа хөдөөгийн эрчүүдийн ажил эрхлэлт аймгийн төвийн эрчүүдийн ажил эрхлэлтээс 14.5 мянга (3.3 дахин их) -аар илүү байгаа нь хөдөөгийн эрчүүдийн дийлэнх нь мал аж ахуй эрхэлж байгаагаар тайлбарлагдана.

АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН

Аймгийн хэмжээнд ажилгүйдлийн түвшнийг тооцож үзэхэд 2020 онд 3.1 хувь болж, өмнөх тооллогын үеийнхээс 16.1 пунктээр буурчээ. Ажилгүй иргэд Хархорин, Уянга, Есөнзүйл, Арвайхээр суманд ихэнх нь байгаа буюу нийт аймгийн хэмжээний ажилгүй иргэдийн 80.1 хувь нь дээрх 4 суманд байна. Ажилгүй иргэдийн дотор 30-44 насныхны эзлэх хувь 43.7 хувь байгаа нь залуучуудын ажилгүйдэл нэлээд өндөр байгааг илэрхийлж байна. Мөн 30-аас дээш насныханд эрэгтэйчүүд илүү их ажилгүйдэлд өртөж байна.

Аймгийн хэмжээнд ажиллах хүчнээс гадуурх хүн ам нийтдээ 28.3 мянга байгаа нь өмнөх тооллогоос 66.4 хувиар, үүний дотор сургуульд сурдаг хүний тоо 66.6 хувиар өсжээ. Харин хөдөлмөр эрхлэх чадваргүй, гэрийн ажилтай, тохирох ажил олдохгүй байгаа хүн амын хувь 32.8 хувиар буурсан байна.

Тогтвортой хөгжлийн зорилтын шалгуур үзүүлэлтийн нэг болох 15-24 насны хүн амд хөдөлмөр эрхэлдэггүй, сургуульд суралцдаггүй залуучуудын эзлэх хувь 13.2 хувь байна.

11. ГАДААДАД ОРШИН СУУГАА ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭД

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын дүнгээр гадаадад оршин суугаа 1 013 иргэн тоологдож, 2010 оноос 16.4 хувиар өсчээ


ЗУРАГ 15. ГАДААДАД ОРШИН СУУГАА ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХҮН АМЫН ТОО, УЛСААР



Гадаадад тоологдсон иргэдийн 44.3 хувь нь Өмнөд Солонгос улсад, 12.7 хувь нь Япон улсад, 8.6 хувь нь Хятад улсад, 8.0 хувь нь Чех улсад тус тус тоологдсон байна.

Гадаад улсад байнга оршин сууж байгаа 1 013 хүн тоологдсоноос 74.7 хувь нь Ази, Номхон далайн бүсэд, 20.2 хувь нь Европ тивд, 3.8 хувь нь Америк тивд, 1.3 хувь нь Африк тивд байн

ЗУРАГ 16. ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭД, ЯВСАН ЗОРИЛГО, ХУВИАР, 2020 ОН



12. СУУЦНЫ НӨХЦӨЛ

Өвөрхангай аймагт нийт 33.0 мянган өрх 23.6 мянган сууцанд амьдарч байна. Амьдарч буй өрхийн тоо, хүн байнга амьдардаг сууцны тооны харьцаа аймгийн төвд ойролцоо байхад, хөдөөд өрхийн тоо нь илүү байна. Энэ нь хөдөөд нэг сууцанд олон өрхүүд хамт амьдарч байгааг харуулж байна.

Төв, хөдөөд амьдарч байгаа өрхийн сууцны төрөл нэлээд ялгаатай байна. Аймгийн төвд нийт өрхийн 16.1 хувь нь байшинд, 11.5 хувь нь гэрт амьдарч байгаа нь өмнөх тооллогын үеийнхээс гэрт амьдардаг өрхийн эзлэх хувь 13.8 пунктээр буурч, байшинд амьдардаг өрхийнх 3.8 пунктээр нэмэгдсэн байна. Энэ нь аймаг хотуудад сүүлийн жилүүдэд орон сууцжуулах бодлого, хөтөлбөрүүд нэмэгдсэнтэй холбоотой юм.

Хөдөөгийн өрхийн 57.4 хувь нь гэрт амьдарч байгаа нь өмнөх тооллогын үеийнхээс 0.6 пунктээр буурч, харин байшинд амьдардаг өрхийн хувь 9.0 пунктээр өссөн байна. Аймгийн төв, хөдөөд байшинд амьдардаг өрхийн тоо өсч байгаа нь тохилог сууцанд суугчдын тоо нэмэгдэхийн зэрэгцээгээр иргэд өөрсдөө байшин барьж суух нь олширч, орон сууцаар хангах бодлого тодорхой хэмжээгээр нөлөөлсөнийг гэрчилнэ.

ХҮСНЭГТ 8. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРӨЛ, 2010, 2020 ОН

	2010		2020	
	Өрхийн тоо	дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	дүнд эзлэх хувь
БҮГД	28 051	100.0	33 062	100.0
Гэр	23 055	82.2	22 816	69.0
Байшин	4 903	17.5	9 998	30.2
Орон сууцны байшин	551	2.0	1 678	5.1
Бие даасан тохилог сууц	36	0.1	157	0.5
Сууцны тусдаа байшин	4 121	14.7	8 056	24.3
Нийтийн байр	195	0.7	107	0.3
Бусад сууц	93	0.3	248	0.8

Орон сууцны байшинд суудаг өрхийн тоо нийт өрхийн 5.0 хувийг эзэлж байгаа нь 2010 оноос 3.0 дахин нэмэгдсэн буюу сүүлийн 10 жилд орон сууцанд амьдардаг айл өрхүүд 1.1 мянгаар нэмэгджээ. Мөн сууцны тусдаа байшинд суудаг өрхийн хувийн жин 2010 оныхоос 9.6 пунктээр, бие даасан тохилог сууцных 0.4 пунктээр тус тус өссөн нь иргэд өөрсдөө байшин барьж суух бололцоо нэмэгдсэнийг харуулж байна. Мөн нийт өрхийн 69.0 хувь нь гэрт амьдардаг ба дийлэнх нь буюу 57.5 хувь нь хөдөөд байна.


ХҮСНЭГТ 9. ГЭР, БАЙШИН, ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРӨЛ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2019, 2020 ОН

	Хүн байнга амьдардаг сууц			Өрхийн тоо		
	Бүгд	Хот	Хөдөө	Бүгд	Хот	Хөдөө
БҮГД	25 871	7 701	18 170	33 062	9 235	23 827
Гэр	16 891	2 629	14 262	22 816	3 820	18 996
Байшин	8 980	5 072	3 908	9 998	5 346	4 652
Бусад сууц	-	-	-	248	69	179

Тайлбар:*Орон сууцны байшингийн доторх сууцыг нэмж оруулав.

Нийт өрхийн 69.0 хувь нь гэрт, 30.2 хувь нь байшинд, 0.8 хувь нь бусад төрлийн сууцанд амьдарч байна. Гэрт амьдардаг өрхийн хувь өмнөх тооллогын үеийнхээс 13.2 пунктээр буурсан бол байшинд амьдардаг өрхийнх 12.7 пунктээр өссөн байна.

ЗУРАГ 17. ӨРХИЙН СУУЦНЫ ТӨРӨЛ, 2020 ОН



Байшин, орон сууцны тооллогоор хүн байнга амьдардаг 23.6 мянган сууц, орон сууцны байшингийн доторх сууцыг оруулбал 25.9 мянган сууц тоологдсон. Харин хүн байнга амьдардаггүй илүү гэр, зуслангийн байшин зэрэг 9.3 мянган сууц тоологджээ.

ЗУРАГ 18. ХҮН АМЬДРАН СУУХ ЗОРИУЛАЛТТАЙ НИЙТ СУУЦ БОЛОН ХҮН БАЙНГА АМЬДАРДАГ СУУЦНЫ ТОО, ТӨРЛӨӨР, 2020 ОН



Тооллогоор хүн байнга амьдардаг сууцнаас сууцны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг амьдарч буй өрхөөс асууж цуглуулсан.

Хүн байнга амьдардаг сууцыг төрлөөр авч үзвэл 65.3 хувь нь гэр сууц, 24.9 хувь нь сууцны тусдаа байшин, 8.9 хувь нь нийтийн зориулалттай орон сууцны байшин, 0.7 хувь нь бие даасан тохилог сууц, 0.2 хувь нь нийтийн байр тоологдсон байна.

Нийтийн зориулалттай 95 орон сууцны байшинд 2 294 сууц тоологдсон байна.